



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ

2021 оны 11 сарын 16 өдөр

Дугаар 13

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.11, 23.2.12 дахь заалт, 39 дүгээр зүйлийн 39.1.7 дахь заалт, 39.14 дэх хэсгийг үндэслэн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар хяналт шалгалт хийж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Ажлын хэсгийн ахлагч:

Ж.Батжаргал

-Улсын Их Хурлын гишүүн

Гишүүдэд:

Т.Аубакир

-Улсын Их Хурлын гишүүн

Б.Бейсен

-Улсын Их Хурлын гишүүн

Г.Мөнхцэцэг

-Улсын Их Хурлын гишүүн

Б.Саранчимэг


-Улсын Их Хурлын гишүүн

2. Ажлын хэсгийн үйл ажиллагаанд шаардлагатай тохиолдолд холбогдох яам, агентлагийн албан тушаалтан, мэргэжлийн хүмүүсийг тухай бүр татан оролцуулахыг зөвшөөрсүгэй.

3. Ажлын хэсгийн санал, дүгнэлтийг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хуралдаанд танилцуулахыг Ажлын хэсэг (Ж.Батжаргал)-т үүрэг болгосугай.

4. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах удирдамжийг батлах, Ажлын хэсэгт зохион байгуулалтын талаар дэмжлэг үзүүлж ажиллахыг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо (Х.Болорчулуун)-нд даалгасугай.

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Х.БОЛОРЧУЛУУН